

Төсөл: Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ

P152343: МОНГОЛ УЛС – ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАРЫН
ХОЁРДУГААР ТӨСЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ 2
(НАРНЫ ЦАХИЛГААН СТАНЦ)

2017 ОНЫ 1-Р САР

ТОВЧ ХУРААНГУЙ	2
БАРИЛГА УГСРАЛТЫН АЖИЛ	ERROR! BOOKMARK NOT DEFINED.
Үйл ажиллагааны нөлөөлөл	ERROR! BOOKMARK NOT DEFINED.
1. УДИРТГАЛ	5
2. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА	5
3. АШИГЛАГДАЖ БОЛЗОШГҮЙ БАЙРШЛУУДЫН ТАНИЛЦУУЛГА	6
3.1 БАЙРШИЛ А (ХОВД АЙМГИЙН МЯНГАД СУМЫН ТӨВ)	6
3.2 БАЙРШИЛ В (УВС АЙМГИЙН ӨМНӨГОВЬ СУМ)	10
3.3 БАЙРШИЛ С (ХОВД АЙМГИЙН МЯНГАД СУМАНД БУЮУ БАЙРШИЛ А-ГААС ХОЙД ЗҮГТ 10 КМ-ИЙН ЗАЙТАЙ БАЙРЛАХ)	13
4. ҮҮСЭЖ БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛЛИЙН ТАНИЛЦУУЛГА	16
4.1 Барилга угсралтын ажлын нөлөөлөл	16
4.2 Үйл ажиллагааны нөлөөлөл	17
5. ГОМДОЛ ШИЙДВЭРЛЭХ ТОГТОЛЦОО	18
6. ХЭЛЭЛЦҮҮЛГҮҮД	19
ХАВСРАЛТ А: НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ МАТРИЦ	20
ХАВСРАЛТ Б: СОНГОГДСОН БАЙРШЛЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ УДИРДЛАГА БА НӨЛӨӨЛӨЛ БУУРУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	22
ХАВСРАЛТ В: ХЭЛЭЛЦҮҮЛГҮҮДИЙН ТОЙМ	38

Товч хураангуй

Монгол Улсын Сангийн Яам ба Эрчим хүчний яам нь Эрчим хүчний салбарын хоёрдугаар төсөл (ESP 2)-д нарны фотовольтийн хэсгийн оруулна гэдгийг Дэлхийн Банкнд баталгаажуулан мэдэгдсэн. Энэ төслийн хүрээнд 10 мегаватт (МВ)-ийн тооцоолсон хүчин чадал бүхий, 25-аас 37.5 га газарт байгуулагдах нэг нарны цахилгаан станц баригдахаар баталгаажуулсан. Энэхүү нарны фотовольтийн станцийг байгуулж болох гурван байршлыг тогтоосон байна. Өмнө нь хоёр байршлыг Сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлэх хөтөлбөр (СЭХНХ)-ийн хүрээнд тогтоосон байсан ба саяхнаас гуравдагч боломжит байршлыг тогтоогоод байна. Энэ Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ (ESIA)-гийн зорилго нь байгаль орчин, нийгмийн хамгааллын өнцгөөс хамгийн тохиромжтой байрлалыг сонгохын тулд эдгээр гурван байршлыг байгаль орчин, нийгмийн талаас үнэлэх юм.

Тогтоогоод байгаа гурван байршил нь Ховд аймаг (Байршил А), Увс аймаг (Байршил В), Ховд аймаг (Байршил С)-т байрлаж байна. Олон улсын хамгааллын зөвлөх нь хамгааллын зохих арга хэмжээний ерөнхий үнэлгээг Байршил А ба Байршил В-д 2016 оны 9-р сараас 10-р сарын хооронд, Байршил С-гийнхийг 2016 оны 11-р сард тус тус гүйцэтгэсэн.

Энэ ерөнхий үнэлгээнд байршлын орчинг (хүн амьдардаг төв, ой мод, байгалийн амьдрах орчин ба амьтдын нүүдлийн маршрут, биет соёлын өв, одоо байгаа дэд бүтэц, усны нөөц, малчдын нүүдлийн чиглэлтэй хэр ойрхон болох) харгалзан авч үзсэн. Нийгмийн үнэлгээний мэдээллийг дотоодын байгууллага болох Mongolian Marketing Consulting Group (ММСГ) ХХК-гийн тусламжтайгаар бас энэ хугацаанд цуглуулсан.

Ерөнхий үнэлгээний үр дүнгээс үзэхэд бүх гурван байршилд нарны фотовольтийн станц барихад байгаль орчин, хамгааллын хувьд багаас дунд хэмжээний эрсдэлтэй, нийгмийн хамгааллын хувьд бага эрсдэл ба нөлөөлөлтэй байсан.

Нөлөөллийн үнэлгээний матрицийг ерөнхий үнэлгээний үр дүнг ашигласан байгуулсан (Хавсралт А-гаас харна уу) ба байгаль орчин, нийгмийн хамгааллын өнцгөөс Байршил А нь хамгийн давуу талтай гэж дүгнэсэн.

Сонгогдсон газрын хувьд, төслийг хэрэгжүүлэгч нарны фотовольтийн байгууламжийг барих ба үйл ажиллагаа явуулахтай холбоотой байгаль орчин, нийгмийн асуудлуудыг тогтоох, хянах, зохицуулахад гарын авлага болгож ашиглах Байгаль орчны удирдлага ба сөрөг нөлөөлөл багасгах төлөвлөгөөг (Хавсралт Б-г харна уу) бэлтгэсэн.

БОУТ-д авч үзсэн үүсэж болзошгүй нөлөөллүүдийг дурдвал:

Барилга угсралтын ажил

Газар ашиглалт

Байршил С-д малчин өрхүүд (1-5 айл) жил болгон хэдэн сар малаа бэлчээдэг газар ашиглагдан эдгээр өрхүүдийг эдийн засгийн шилжилт хийлгэж болзошгүй байна. Бусад мал бэлчээхэд ашиглаж болох газрууд хангалттай байгаа тул нөлөө бага байна. Байршил А ба В нь ямар нэгэн хүн ашиглаж эсвэл амьдраагүй төрийн эзэмшлийн газар байна.

Нийгэм

Богино хугацааны ажлын байр ба орон нутгаас ханган нийлүүлэх боломж бий болох учраас нийгмийн нөлөөлөл голдуу эерэг байна. Богино хугацааны (түр зуурын) сөрөг нөлөөлөлд БОУТ-ний дагуу зохицуулагдах барилга угсралтын ажлаас болж үүсэх дуу чимээ/тоос (доор дурдсан) ба түр зуур шилжин ирэх ажилчид (6 сарын хугацаанд 200-гаас доош тооны хүн) байх болно.

Агаарын чанар

Тээврийн хэрэгсэл ба тоног төхөөрөмжийн хөдөлгөөн эсвэл барилга угсралтын хадгалагдсан материалаас моторын утаа, тоос дэгдэлт үүсч болохоор байна.

Дуу чимээ

Орон нутгийн орон суугчид ба зэрлэг амьтдын зан үйл, дадлыг алдагдуулж болохуйц дуу чимээ гаргаж болно.

Гадаргын урсацийн чиглэлийн өөрчлөлт

Газар цэвэрлэх ба газрын гадаргууны хэлбэрт өөрчлөлт хийх үйл ажиллагаа нь гадаргын урсацын чиглэлийг өөрчлөн, тухайн орчин бүст үерлэлт бий болгох боломжтой

Хөрс хуулалт

Газар бэлтгэх үйл ажиллагаанд хөрс хуулах/хадгалах үйл ажиллагаа орж болзошгүй

Ургамлын хаягдал гарах

Газар бэлтгэх үйл ажиллагаанд одоо байгаа ургамлыг цэвэрлэх/зайлуулах үйл ажиллагаа орж болзошгүй

Барилга угсралтын ажилтай холбоотой хатуу хог хаягдал

Аюулгүй: Баглаа боодол, барилга угсралтын идэвхгүй материалын хаягдал мөн магадгүй ажилчдын кампийн ахуйн хог хаягдал

Аюултай: ашигласан тос, тослох материал, илүүдэл будаг эсвэл гадуур бүрхэх материал, цавуулаг бодис

Хаягдал ус

Цэвэрлэх тоног төхөөрөмжөөс гарах хаягдал ус буюу магадгүй эрүүл ахуйн байгууламж болон ажилчдын кампаас гарах ахуйн хаягдал ус

Соёлын өв

Малтлагын үйл ажиллагааны үеэр соёлын, шашны эсвэл түүхийн ач холбогдол бүхий түүхийн эд өлгийн зүйлс санамсаргүй олдох нь бий

Ажилчдын аюулгүй байдал

Барилга угсралтын үйл ажиллагаа нь ажилчдыг аюулгүй байдал, эрүүл мэндэд нь нөлөөлж болзошгүй нөхцөл байдалд ажиллах, эд материалтай харьцахад хүргэнэ.

Үйл ажиллагааны нөлөөлөл

Нийгэм

Тус хөрөнгө оруулалтын хамрах хүрээнд цахилгаан хангамжийн үйлчилгээнд ямар нэгэн хэрэглэгчийг шинээр холбохгүй гэж тооцоолж байгаагаас гадна уг хөрөнгө оруулалтын үр дүнд шинэ холболт бий болохгүй гэж тооцоолж байна. Одоогийн нөхцөлд Орос улсаас байнгын бөгөөд найдвартай цахилгаан хангамжийг авч ашигладаг мөн хэрэглэгчид (төв суурин газруудад) аль хэдийн уг үйлчилгээнд холбогдсон байгаа тул цахилгаан хэрэглэгчийн үнэнд өөрчлөлт орох болон

найдвартай байдал нэмэгдэх боломж зэрэг тооцоологдоогүй болно. Ойролцоогоор 10-30 тооны ажилтан нарны фотовольтийн станцийн үйл ажиллагааг явуулахад шаардлагатай бөгөөд эдгээр ажилтнуудыг ажиллах, ажиллах чадвартай болгохын тулд сургалт явуулах хэрэгтэй болно. Бүх ажилд авсан ажилтнуудын мэдлэг, чадварыг сайжруулах шаардлагатай байгаа нь нарны цахилгаан станц байгуулсны үр дүнд орон нутгийн чадварлаг ажилчид, эмэгтэйчүүдэд шинээр чадвар эзэмших, ажилтай болох боломжийг бий болгоно.

Үзэгдэх орчны сарнилт

Нарны цахилгаан станцийн хавтангаас нарны гэрэл ойход жолоочдын хараанд нөлөөлөхөөс гадна нүүдлийн шувуудын нислэгийн чиглэлийг сарниулах магадлалтай

Газар доор ус хэрэглэх боломж

Уламжлалт хавтанг ашиглабал тодорхой хэмжээгээр газар доорх ус багасах ба улмаар газар доорх усны дээд түвшинг бууруулж болно. Гэхдээ хавтангийн загвараар хуурай, өөрийгөө цэвэрлэдэг систем сонгогдвол газар доорх усны хэрэглээ маш бага байна (ажилчдын эрүүл ахуйн шаардлагад нийцэхээр). Энэ асуудлыг төслийн байршил дах боломжит усны нөөцийг шалгах үйл ажиллагааг оролцуулан нарны хавтангийн эцсийн дизайны үе шатанд тооцон оруулна.

Хавтанг угаасан хаягдал ус

Уламжлалт хавтанг ашиглабал хавтан угаасан хаягдал усанд бохирдуулагч бодис байх магадлалтай ба хүлээн авах усны эх үүсвэрийг бохирдуулж болзошгүй

Аюултай хаягдал

Арчилгааны үеэр хэлхээ салгуур, эргэх хувиргагч ба трансформатороос гоожсон тос нь хөрсийг бохирдуулах боломжтой

Экологи

Нарны фотовольтийн хавтангууд болон дамжуулалтын шугамын маршрутанд сонгогдсон байршлуудын аль аль нь нүүдлийн шувуудын маршрут болон газарт үүрээ засдаг шувуудын үүрээ засах хэлбэр байдал, газар дээр зэрлэг амьтадын нүүдлийн чиглэл эсвэл мал аж ахуйн бэлчээрийн газарт хамаарч магадгүй юм.

Дэлхийн Банкны ТУЗ-аар батлагдсаны дараа төсөлд нэмж нарны цахилгаан станц байгуулахыг оруулж магадгүй. Энэ боломжийн улмаас авч үзэж болох аливаа боломжит байршил нь Монгол Улс ба Дэлхийн Банкны хамгааллын шаардлагыг хангахад зээлдэгчид чиглэл өгөх зорилгоор бие даасан Байгаль орчин, нийгмийн удирдлагын хүрээ (БОНУХ)-ний баримт бичгийг бэлтгэсэн болно.

1. Удиртгал

Монгол Улсын Сангийн Яам ба Эрчим хүчний яам нь Эрчим хүчний салбарын хоёрдугаар төсөл (ESP 2)-д нарны фотовольтийн хэсгийн оруулна гэдгийг Дэлхийн Банканд баталгаажуулан мэдэгдсэн. Энэ төслийн хүрээнд 10 мегаватт (МВ)-ийн тооцоолсон хүчин чадал бүхий, 25-аас 37.5 га газарт байгуулагдах нэг нарны цахилгаан станц баригдахаар баталгаажуулсан. Энэхүү нарны фотовольтийн станцийг байгуулж болох гурван байршлыг тогтоосон байна. Өмнө нь хоёр байршлыг Сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлэх хөтөлбөр (СЭХНХ)-ийн хүрээнд тогтоосон байсан ба саяхнаас гуравдагч боломжит байршлыг тогтоогоод байна. Гурван байршлын байрлалыг доор газрын зурган дээр харууллаа.



Энэ Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ (ESIA)-гийн зорилго бол байгаль орчин, нийгмийн хамгааллын өнцгөөс хамгийн тохиромжтой байрлалыг сонгохын тулд эдгээр гурван байршлыг байгаль орчин, нийгмийн талаас үнэлэх юм.

2. Төслийн танилцуулга

Нарны фотовольтийн станц нь нарны цацрагийн эрчим хүчийг ашиглаж болох цахилгаан болгон хувиргах болно. Станц нь нарны зайны цуваа ба системийн бүрэлдэхүүн хэсгүүдийн балансас тогтоно. Станц бол шугам сүлжээнд холбогдсон, газарт суурилуулсан систем гэж ангилагдах ба талстан цахиураар хийгдсэн тогтмол хазайсан нарны хавтангуудаас тогтох болно. Санал болгогдож байгаа төсөл нь 10 мегаватт (МВ)-ийн тооцоолсон хүчин чадал бүхий, 25-аас 37.5 га газарт 30,000-аас 70,000 нарны хавтан байрлуулах шаардлагатай байхаар төлөвлөгдсөн.

Нарны зайг цаг агаараас хамгаалахын тулд нарны модуль дотор хадгалах болно. Модуль нь бэхжүүлсэн шилэн хамгаалалт, цаг агаар ба галд тэсвэртэй материалаас тогтох арын давхарга, хөнгөн цагаан хүрээнээс тогтоно. Зайнууд нь цахилгаанаар холбогдон, өндөрсөгсөн дэмжих бүтэц дээр суурилуулан нарны модулийг үүсгэнэ. Эгнэсэн модулиудыг “нарны хавтан” гэж нэрлэх бөгөөд нэг болон түүнээс дээш хоорондоо холбогдсон хавтанг нарны зайны цуваа гэдэг. Нэг модуль бараг

1 метр квадрат бөгөөд өдөрт барагцаагаар 0.75 киловатт-цаг (kWh) цахилгаан үүсгэнэ. Ирж байгаа гэрлийг шингээж авахын тулд нарны ПВ модульд ойлтын эсрэг бүрхүүл ашигладаг ба энэ нь жолоочдод аюул учруулах болон нүүдлийн шувуудын нислэгийн чиглэлд нөлөөлж болохуйц гялбах, гэрэлтэх ойлтыг бууруулна.

Ашиглалтын үеэр уламжлалт хавтангийн дизайн бүхий фотовольтийн хавтангийн гадаргууг цэвэрлэхэд 6 сар тутам 410,000-аас 615,000 литр ус шаардлагатай болно. Гэхдээ хавтангийн загвараар хуурай, өөрийгөө цэвэрлэдэг систем сонгогдвол газар доорх усны хэрэглээ маш бага байна (ажилчдын эрүүл ахуйн шаардлагад нийцэхээр). Байршил бүр нь хэт тоосжилттой биш. Хавтанг огцом өнцөгт (ойролцоогоор 45 градус) байлгана. Иймээс бороо ороход тодорхой хэмжээний цэвэрлэх нөлөө үзүүлнэ гэж үзэж байна.

Уламжлалт хавтангийн дизайны хувьд цэвэрлэх давтамжийг цахилгааны гаралтын бодит явц ба газар дээр нь шалгасан үр дүнгээс хамааран шинэчилэх болно. Угаахад ашигласан усыг цэвэршүүлэлгүйгээр хаяна. Учир нь хавтан дээр тогтсон тоосыг арилгахад эдгээр ус зөвхөн дүүжлэгдсэн хатуу биет агуулах ба ямар нэгэн тодорхой менежментийн асуудал бий болгохгүй. Хэдий тийм боловч эхний хоёр угаах үйл ажиллагаанаас үүссэн хаягдал уснаас тодорхой тооны боломжит бохирдуулагчдын шинжилгээг авах ба хэрвээ хаягдал усны чанарын шинжилгээнээс цэвэршүүлэх шаардлагатай гэж үзэх юм бол хаягдал усыг цэвэршүүлэх газар төслийн байршилд зориулан гаргах болно.

Аливаа сонгогдсон байршил нь хамгийн ойрын дэд станцтай холбогдох шаардлагатай. Станцаас гарч байгаа эрчим хүчний гаралтыг 0.5 км урттай дамжуулах шугамыг ашиглан одоо байгаа шугам сүлжээнд холбох ба зэрлэг амьтдын нүүдлийн маршрутын байгаль орчны асуудлаас хамааран дамжуулах шугамыг газар доогуур байгуулан, хамгийн ойрын дэд станцтай холбохоор байна. Мөн шугам сүлжээнд цахилгаан өгөхын тулд үүссэн DC эрчим хүчийг хувиргагч ашиглан AC болгох шаардлагатай. Хувиргагч нь шугам сүлжээний давтамжтай адил болон таарах болно.

3. Ашиглагдаж болзошгүй байршлуудын танилцуулга

Гурван байршил тус бүрийн танилцуулгын доор дурдлаа.

3.1 БАЙРШИЛ А (ХОВД АЙМГИЙН МЯНГАД СУМЫН ТӨВ)

Байршил А-гийн сүүлийн үеийн зургийг доор тавилаа.

Site A : Mayangad substation (From North to South)



Газар ашиглалт (Одоогийн)

Санал болгож байршил нь Мянгад сумын төвөөс 1 км зайтай, одоо байгаа дэд станцийн хажууд юм. Одоо байгаа Мянгад дэд станц (2 x 110/ 35/ 6кВ) нь Ховд аймгийн Дөргөн усан цахилгаан станцаас 100 кВ дамжуулах шугам, Оросоос эрчим хүч нийлүүлэх 110 кВ дамжуулах шугам (Өмнөговь дэд станцаар дамжина), 110 кВ-ийн Говь-Алтай аймгийн зарим сумын эрчим хүчээр хангах дамжуулах шугам, 35 кВ-ийн Ховд аймгийн Ховд хот, Эрдэнэбүрэн сум, Дуут сум уруу эрчим хүч дамжуулах шугамаас тогтоно.

Мянгад сумын Засаг даргын тамгын газраас Байршил А (аливаа холбогдох дамжуулах шугамыг оруулан) нь төрийн мэдлийн газар болохыг баталгаажуулсан. Дэд станц эргэн тойрны бүх газрыг нарны цахилгаан станцийн байгууламжинд ашиглах боломжтой болгож болно. Хэрвээ сонгогдох юм бол 15-60 жилийн хооронд хугацаатай зөвшөөрөл олгох болно. Засаг даргын тамгын газар ба олон улсын хамгааллын зөвлөхийг ажиглалтын дагуу уг газар хөдөө аж ахуй (бэлчээрийн мал аж ахуй) эсвэл ямар нэгэн үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд албан ёсоор эсвэл албан бусаар ашиглагддаггүй болохыг баталсан. Албан ёсоор эсвэл албан бусаар санал болгосон төслийн байршилд амьдардаг хүн байхгүй. Санал болгосон төслийн байршилд ямар ч өвлийн байгууламжууд байхгүй байна.

Газар ашиглалт (Ирээдүйд)

Мянгад сумын Засаг даргын тамгын газарт газрын яг хэмжээ/хэмжээс ба байрлал тодорхой болохоор 15-60 жилийн хугацаатай тусгай зөвшөөрөл олгох эрх мэдэлтэй болно. Түүнчлэн Сумын Засаг дарга төслийг дэмжиж байгаагаа илэрхийлсэн.

Байршил А дээр ирээдүйд газар ашиглалтын ямар нэгэн төлөвлөгөө ба сумын төвд ямар нэгэн газар ашиглах төлөвлөгөө байхгүй байна.

Нийгэм

2015 оны байдлаар Ховд аймгийн (80,366 хүн) Мянгад сумын хүн ам 3,587 байгаа бөгөөд үүнээс 2,436 нь 15 болон түүнээс дээш настай байна. Мянгад сум нь 5 багтай (захиргааны нэгж) ба 5-р баг (Баянхошуу) бол сумын төв юм. Энэ баг нь малчид, тариаланчид, сумын төвийн суурин гэсэн 3

үндсэн хэсэгт хуваагддаг. 2015 оны байдлаар Баянхошуу багт 838 хүн буюу барагцаагаар 210 өрх амьдарч байна. Сумын төв нь цэцэрлэг, бага сургууль, дунд сургуультай. Сумын ажиллах хүч зуны саруудад гурван тоосгоны үйлдвэрт ажилладаг бөгөөд эдгээр ажиллаж байгаа хүмүүсийн барагцаагаар 30% нь эмэгтэй. Эдгээр саруудад 600,000-аас 2 сая төгрөг хүртэлхи өндөр цалин авдаг. Одоогоор сумын төвд ямар нэгэн зочид буудал, зочин хүлээж авах газар байхгүй. Тоосгоны үйлдвэрээс гадна айл өрхүүд мал малладаг. Бүх өрх айлууд ба байгууллагууд цахилгааны шугам сүлжээнд холбогдсон.

Ой мод

Санал болгосон байршилд ой мод байхгүй. Өмнө зүгт 12.5 км зайтай Чухал шувууны бүс бүхий үндэсний парк Хар Ус нуур (Рамсар газрыг оруулан) байдаг. Санал болгосон байршил ой модгүй боловч Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуучлалын яам (БОНХАЖЯ), Ойн бодлого, зохицуулалтын газрын захирлаас зөвшөөрөл авах шаардлагатай.

Биет соёлын өв

Сумын байгаль орчин, газрын мэргэжилтнүүдийн хэлсэний дагуу ямар нэгэн мэдэгдэх биет соёлын өв байхгүй байна. Хамгийн ойрхон албан ёсоор хүлээн зөвшөөрөгдсөн биет соёлын өв нь төслийн байршилаас барагцаагаар 45 км-т байрлах Сангийн хэрэм болно. Сангийн хэрэм нь Ховд аймгийн хойд хэсэгт байх Манжийн үеийн хэрмийн үлдэгдэл юм. Хэрмийн 18-р зуунд байгуулсан бөгөөд сүүлд Манжийн амбангийн байрлах газар болсон. Хэрэм нь дөрвөлжин зохион байгуулалттай, ханыг шавраар хийжээ.

Усны нөөцний хангамж ба удирдлага

Орон нутгийн сумын захиргааны холбогдох албан тушаалтнууд байршил А-гийн газар доорх усны нөөц хангалттай (элбэг) гэж мэдэгдсэн. Байршлын ойролцоо худаг ажиглагдсан. Гэвч ус хэрэглэх боломжийн талаар тодорхой мэдээлэл өгөөгүй. Мянгад дэд станцийн хажууд ажиглагдсан худаг засаг захиргаанд албан ёсоор бүртгэлтэй биш болохоор багтаамж нь тодорхойгүй.

Мянгад сумын Засаг дарга нь Мянгад сум хангалттай усны нөөцтэй гэж мэдэгдсэн. Засаг даргын тамгын газрын байгаль орчны ажилтан газар доорх усны нөөцийг цаашид ашиглах боломж бий гэсэн. Одоогоор усыг хөдөө аж ахуй, ундны ус болгон, хоол хийхэд ашиглаж байна.

ОУСК-ийн байгууламж баригчийн зааварчилгааны дагуу станцад шаардлагатай усны нөөцийн хэрэгцээ жилд 410 м³ байна (41 м³/жил/МВ).

Уг газар хавар ба намар ерөнхийдөө салхитай байдаг учраас эдгээр үеүүдэд хавтанг илүү их угаах шаардлагатай болно.

Дизайн буюу төлөвлөлтийн үйл ажиллагааны нэг болгон Дэлхийн Банкнаас санал болгож буй төслийн байршил дах газар доорх усны худгийн гарцны баталгаатай мэдээлэлтэй болоход үндсэн шаардлагын үнэлгээний арга хэмжээг Мянгад сумын засаг даргын тамгын газрынхны санал бодлыг баталгаажуулах зорилгоор гүйцэтгэнэ. Үндсэн шаардлагын үнэлгээний хүрээнд уг мэдээллийг цуглуулах оролдлого амжилтгүй болох тохиолдолд Дэлхийн Банкнаас ямарваа төслийн төлөвлөлтийн үйл ажиллагааг үргэлжлүүлэхийн өмнө уг мэдээлэлтэй болох талбарын судалгааг зохион байгуулна.

Хавтанг цэвэрлэхэд химийн нэмэлт бодис ашиглахыг хориглоно. Иймээс хэрэв усаар цэвэрлэхэд байх бохирдуулагч бол нарны хавтангийн тоосыг угаахад үүсэх хаягдал усанд байх дүүжлэгдсэн хатуу биет байх болно. Эхний хоёр удаагийн угаалтын дараах хаягдал усны чанарын шинжилгээгээр цэвэрлэгээ шаардлагатай гэж тогтоогдох тохиолдолд цэвэрлэх байгууламжид зориулсан газрыг тусгайлан гаргана.

Экологи

Үндсэн шаардлагад нийсэн байдлын үнэлгээний дагуу байршил (санал болгосон дамжуулах шугамын замыг оруулан) нь ямар нэгэн албар ёсоор хамгаалагдсан газар байгуулагдахгүй ба ой мод устгахад хүргэхгүй. Гэвч сонгогдсон байршил Рамсар газраас ойролцоогоор 12.5 км-ийн зайтай бөгөөд Ховд голтой огтлолцох Хар Ус нуурын чухал усны шувууны бүс байдаг. Орон нутгийн иргэд Ховд гол ба Хар Ус нуурын ойролцоо газраар шувууд их нисдэг, дэлхийд ховордсон цагаантолгойт ямаансүүлт (*Oxyura leucoserphala*) үрждэг чухал газар гэж дурдсан.

Дэлхийн байгаль хамгаалах сан (ДБХС)-гийн төлөөлөгчидтэй хийсэн үүлзалтаас үзэхэд байршил нь орон нутгийн замтай ойрхон учраас зэрлэг амьтадтай тааралдах магадлал бага гэсэн. Монгол Улсын Зэрлэг амьтан судлах хамгаалах төвийн төлөөлөгчидтэй хийсэн үүлзалтанд бут хайхыг эс тооцвол цөөхөн тооны шувууд хуурай газар ашигладаг болохыг дурдсан. Нарны цахилгаан станцийн төсөл нам доор газар байрлах бутанд үүрээ засдаг Монгол хуланжороонд (BirdLife International-ийн мэдээлснээр Улаан номны жагсаалтны “ховордоогүй” ангилал)¹ саад болж болзошгүй.

Монгол Улсын Зэрлэг амьтан судлах хамгаалах төвийн төлөөлөгчид тэр хавиар голчлон нисдэг шувууд нэг бол голын баруун хэсэг нүүдэллэх алтан гургалдай эсвэл өндөрт нисэх хандлагатай байдаг махчин шувууд байдаг учраас ПВ хавтанг шувуу мөргөх магадлал бага гэсэн. Дамжуулах шугамыг шувуу мөргөх эрсдэлтэй боловч үүнээс сэргийлэх арга хэмжээг мэдэх бөгөөд эдгээр аргууд нь маш сайн үр дүнтэй, хямдхан (зайлуулагч) эсвэл хэрэв шаардлагатай бол шугамын хэмжээ хангалттай бага (0.5 км дотор) тохиолдолд түүнийг газар доор суурилуулах нь эдийн засгийн хувьд боломжтой байх болно.

Нарны фотовольтийн станц ба холбогдох дамжуулах шугам нь янз бүрийн зэрлэг амьтдын нүүдлийн маршрутад нөлөөлж болзошгүй асуудал байна. Зээлдэгч нь чухал байгалийн амьдрах орчныг тодорхой хэмжээгээр өөрчлөхгүй байх ба/буюу чухал биш байгалийн амьдрах орчны хувьд нарны цахилгаан станц/дамжуулах шугам нь чухал биш байгалийн амьдрах орчинд нөлөөлж болохоор байгаа, болох магадлал багатай үйл явдал болсон тохиолдолд авах тохирох нөлөөллийг бууруулах арга хэмжээг бэлтгэсэн байхад Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуучлалын яам (БОНХАЖЯ)-ны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газраас зөвшөөрөл авах ёстой. АНУ-ын Калифорни мужийн нарны эрчим хүчний фермийн саяхны туршлагаас харахад нүүдлийн шувууд хэвтээ байрлуулсан хавтангуудтай мөргөлдсөн ба энэ тохиолдолд шувууд хавтангуудыг нүүр байна гэж андуурч харсан гэж үзсэн. Гэхдээ нарны чиглэлийн дагуух Монгол улсын газар зүйн байршлаас шалтгаалан хавтангуудыг нарны цацрагийг дээд хэмжээгээр шингээх зорилгоор ойролцоогоор 45°-д хазайлгах ба шувууд нарны зайн цувааг ямар нэгэн усны эхтэй андуурахгүй болно.

¹ BirdLife International-ийн мэдээлснээр Монголын хуланжороо нь “ховордоогүй” гэсэн ангилалд хамаардаг байна. Энэ төрлийн шувууд нь олон төрлийн газар амьдардаг: Монгол, Казакстан ба Хятад улсуудыг хамарсан ойролцоогоор 2, 310,000 хавтай дөрвөлжин километр газар. Тус төсөл нь дээд тал нь ойролцоогоор 40 га буюу 40,000 хавтгай дөрвөлжин метр газрыг хамарна. Төсөл уг төрөл зүйлийн амьдрах газрын жижигхэн хувийг хамарна.

Ойрхон байх дэд бүтэц

Байршил А-тай хамгийн ойрхон зам 0.5 км-ийн зайтай, хамгийн ойрхон галт тэрэгний зам бол байршлаас 895 км-ийн зайтай байх Эрдэнэт хотод байна. Төслийн байршлын ойролцоо Сумын хуучин орон нутгийн хогийн цэг байна. Үүнтэй ойрхон шинэ, зохих байдлаар ашиглагддаг орон нутгийн хаягдлын байгууламж баригдсан. Хоёр хог хаягдлын цэгийн эзлэх хэмжээ бага (барагцаагаар 1 га). Олон улсын хамгааллын зөвлөхүүдийн ажигласнаар болон орон нутгийн захиргаанаас баталгаажуулсаны дагуу зөвхөн орон нутгийн хаягдлыг эдгээр хоёр цэгт хаяж байгаа болно. Шувуу ба амьтад ажиглагдаагүй. Сумын Засаг дарга хэрэв шаардлагатай бол хуучин хогийн цэгийн хаягдлыг шинэ цэг рүү шилжүүлэх боломжтой гэж мэдэгдсэн.

Сумын төвд хаягдал ус цэвэршүүлэх байгууламж байхгүй. Голчлон хаягдал усыг (угаалга үйлдэх, угаах, хоол хийхээс үүссэн) айл гэрийн гадаах нүх эсвэл бохирын байгууламжтай холбогдоогүй гэрийн гадаах нүхэн жорлонд хаяж байна. Сумаас өмнө зүгт хаягдал усны нүх байдаг боловч үүнийг ерөнхийдөө нутгийн иргэд ашигладаггүй.

3.2 БАЙРШИЛ В (УВС АЙМГИЙН ӨМНӨГОВЬ СУМ)

Байршил В-гийн сүүлийн үеийн зургийг доор тавилаа.

Site B : Umnugobi substation (From East to West)



Umnugobi Substation

Газар ашиглалт (Одоогийн)

Байршил В нь Оросоос (Увс аймгийн Улаангом хотын хойд зүгээс) ирж байгаа 110 киловольт (кВ)-ийн дамжуулах шугам, Өлгий сум уруу 35 кВ-ийн дамжуулах шугам, Өмнөговь сум уруу 10 кВ-ийн дамжуулах шугам, Ховд/Баян-Өлгийн аймаг (өмнө зүг) рүү 110 КВ дамжуулах шугам бүхий Өмнөговь сумын төвийн дэд станцийн (110/35/10кВ) хажууд байрлаж байна. Энэ дэд станц Өмнөговь сумын төвөөс 2 км зайтай газар оршиж байна.

Өмнөговь сумын Засаг дарга боломжит төслийн газар (барагцаагаар 15+ га) нь төрийн мэдлийн газар бөгөөд хэрвээ төсөлд шаардлагатай бол ойр орчмын газрыг ашиглах боломжтой гэж мэдэгдсэн. Газар ашиглах зөвшөөрлийг 15-30 жилийн хугацаатай авч болно. Засаг даргын тамгын газар ба олон улсын хамгааллын зөвлөхийг ажиглалтын дагуу уг газар хөдөө аж ахуй (бэлчээрийн мал аж ахуй) эсвэл ямар нэгэн үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд албан ёсоор эсвэл албан бусаар ашиглагддаггүй болохыг баталсан. Албан ёсоор эсвэл албан бусаар санал болгосон төслийн байршилд амьдардаг хүн байхгүй. Санал болгосон төслийн байршилд ямар ч өвлийн байгууламжууд байхгүй байна.

Газар ашиглалт (Ирээдүйд)

Байршил В-гийн газрыг одоогийн байдлаар ашиглаагүй байна. Өмнөговь дэд станцийн баруун талын 10 га газрыг 2016 оны 9-р сарын 27-ноос эхлэн ББЭХС (Баруун Бүсийн Эрчим Хүчний Систем) сэргээгдэх эрчим хүчний зорилгоор 30 жилийн хугацаатай түрээслэсэн байна. Өмнөговь дэд станцийн зүүн өмнөд талд хэсэгт саяхан хувийн компани 15 жилийн хугацаатайгаар (5 га газар) сэргээгдэх эрчим хүчний үйл ажиллагаанд ашиглах зорилгоор зөвшөөрөл авсан байна. Өмнөговь сумын Засаг дарга хувийн компани байршил В-гийн нөгөө талд нарны цахилгаан станц барих төлөвлөгөөтэй байгаа гэж мэдэгдсэн. Хэдий тийм боловч зөвшөөрөл авсаныхаа дараа ямар нэгэн тодорхой үйл ажиллагаа явуулаагүй байна. Дээрхээс бусдаар байршил В-гийн өөр ямар нэгэн ирээдүйн төлөвлөгөө байхгүй байна.

Нийгэм

2015 оны байдлаар Увс аймгийн (80,763 хүн) Өмнөговь сумын хүн ам 4,459 байгаа бөгөөд үүнээс 2,873 нь 15 болон түүнээс дээш настай байна. Өмнөговь сум 5 багтай (захиргааны нэгж) ба 5-р баг (Намир) нь сумын төв юм. Энэ багт 2015 оны байдлаар 1,335 хүн амьдарч байна. Увс аймгийн Түргэн сумын хүн ам бол 2,132 ба 575 өрхтэй байгаа бөгөөд үүнээс 1,417 нь 15 болон түүнээс дээш настай байна. Сум улирлаас хамааран барагцаагаар 2,000 оршин суугчидтай болно.

Сумын төв гурван сургуультай: 2 бага (5-р анги ба түүнээс доод) сургууль нийлээд 250 сурагчтай ба нэг нь хувийнх, нөгөөх нь улсынх; 5-аас 12 хүртэлх ангитай 1 сургууль барагцаагаар 1000 сурагчтай байна. Нийтдээ сумын төвд 1250 сурагч сургуульд сурч байна. Үүн дээр нэмж барагцаагаар 250 хүүхэдтэй 1 цэцэрлэг байна. Сумын төвд гурван зочид буудал байна. Сумын төвд гурван зочид буудал ба тодорхой тооны кафе/ресторан үйлчилгээ үзүүлж байна.

Увс аймгийн Өмнөговийн гол эдийн засгийн салбар бол мал маллах ба газар тариалан эрхлэх байна. 65 ба түүнээс дээш тооны үйлчилгээний ба төрийн байгууллага байна. Сумын үйлдвэрлэлийн 80.0%-ийг хөдөө аж ахуй, 13%-ийг уул уурхайн салбар бүрдүүлж байна. Сумын хүн амын нягтрал ихэссэнээс болж Өмнөговь суманд дараах бодит асуудлууд тулгараад байна: i) ажлын байрны дутагдал, ii) төвлөрсөн халаалтын систем байхгүйн улмаас агаарын бохирдол нэмэгдэж байна, iii) дотуур байрны хүртээмж муу, iv) цахилгаан тогтмол тасарч байна.

Сумын нийтийн аж ахуйн үйлчилгээнүүдийн хувьд бол бизнесийн нэгж, байгууллагууд өөрсдийн халаалтаа түс түсдаа бага даралтын зуухаар шийддэг. Засаг даргын Тамгын газар, эрүүл мэндийн төв, соёлын төв, дунд сургууль зэрэг төрийн байгууллагууд 8 уурын зуухаар халаалтаа шийддэг. Хэдийгээр сумын айл өрх бүр цахилгаанд холбогдсон боловч захын бүсүүдээр цахилгааны хүчдэл муу бөгөөд цахилгаан тогтмол тасардаг.

Нарны цахилгаан дэд станцид зориулан төлөвлөсөн газрын баруун хойд зүгт сумын төвд хогийн цэг байгаа. Хогийн цэгт сумын оршин суугчдын гал түлсэний улмаас үүссэн мод, нүүрс, үнс гэх мэт гэр ахуйн хаягдал ихэвчлэн байхаас гадна мөн барилгын материалын хаягдал байна. Сумын төвд үндны ус хүргэх 15 гүний худагтай бөгөөд ихэнхи айлууд, бизнесийн нэгжүүд, байгууллагууд ус түгээх байраас усаа авдаг. Гэвч сумын усны хатуулаг чанар өндөр байна. Сумын төвд цэвэрлэх байгууламж байхгүй бөгөөд айл өрхүүд, бизнесийн нэгж, байгууллагууд тус тусдаа хаягдал усыг хаяхын тулд нүх ба нүхэн жорлонтой байдаг.

Ой мод

Судлан тогтоосны дагуу байршил (санал болгосон дамжуулах шугамын маршрутыг оруулан) нь ямар нэгэн албан ёсны хамгаалагдсан бүс нутагт хамаарагдахгүй ба ой мод устгахад хүргэхгүй.

Санал болгосон байршил ой модгүй боловч Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуучлалын яам (БОНХАЖЯ), Ойн бодлого, зохицуулалтын газрын захирлаас зөвшөөрөл авах шаардлагатай.

Биет соёлын өв

Сумын байгаль орчин, газрын мэргэжилтнүүд ямар нэгэн мэдэгдэх биет соёлын өв байхгүй гэж мэдэгдсэн. Өмнөговь сумын Засаг дарга хамгийн ойрхон албан ёсоор зөвшөөрөгдсөн биет соёлын өв бол төслийн байршлаас 20 км зайтай байрлах Цагаан булан (хадны зураг) гэж мэдэгдсэн. Хэдий тийм байгаа боловч Өмнөговийн захиргааны ажилтнууд ерөнхий Сумын байрлаж байгаа газар археологийн олдвороор алдартай учраас мэргэжлийн археологийн байгууллагаар урьдчилсан хайгуулын судалгаа явуулахыг зөвлөсөн.

Усны нөөцийн хангамж ба удирдлага

Усны нөөц Мянгад дахь байршлаас илүү хязгаарлагдмал. Орон нутгийн сумын захиргааны холбогдох албан тушаалтнууд газар доорхи ус хязгаарлагдмал болохыг мэдэгдсэн. Байршлын хажууд худаг байдаг болох нь ажиглагдсан. Голын гадаргууны усны нөөц санал болгосон байршлаас барагцаагаар 7-10 км зайтай ба Хар Ус нуур нь санал болгосон байршлаас 2 км-ийн зайтай байна. Өмнөговь дэд станцид Баруун Бүсийн Эрчим Хүчний Системийн эзэмшдэг гүний худаг байдаг. Гэвч энэ худаг албан ёсоор бүртгэгдээгүй болохоор багтаамж нь тодорхойгүй байна.

Хавтанг цэвэрлэхэд химийн нэмэлт бодис ашиглахыг хориглоно. Иймээс хэрэв усаар цэвэрлэхэд байх бохирдуулагч бол нарны хавтангийн тоосыг угаахад үүсэх хаягдал усанд байх дүүжлэгдсэн хатуу биет байх болно.

Экологи

Үндсэн шаардлагад нийсэн байдлын үнэлгээний дагуу байршил (санал болгосон дамжуулах шугамын замыг оруулан) нь ямар нэгэн албар ёсоор хамгаалагдсан газарт байгуулагдахгүй ба ой мод устгахад хүргэхгүй. Гэвч сонгогдсон байршил нь усны шувуудаар баялаг албан ёсоор зөвшөөрөгдсөн чухал шувууны бүс нутгийн захад байна. Ялангуяа онцлон тэмдэглэх зүйл бол Хар Ус нуур бол Рамсар газар болно. Нууранд зун нууранд байх эсвэл нүүдэллэх замаараа нуураар өнгөрөх усны шувууд байрладаг. Хэд хэдэн дэлхийд аюулд орсон эсвэл ховордсон шувууд (Цагаантолгой ямаансүүлт, Гээгт нугас, Хошуу галуу, Борцгор хотон, Усны нөмрөг бүргэд) байрладаг. Түүнчлэн бүс нутагт амьдрах улсын хэмжээнд ховордсон амьтдыг дурдвал: Гангар хун, Монгол хуланжороо (Байршил А-д дурдсныг үзнэ үү).

Өмнөговь дэд станцаас зүүн зүгт (~64 км-т) Хяргас байгалийн цогцолбор газар байдаг.

Монгол Улсын Зэрлэг амьтан судлах хамгаалах төвийн зүгээс санал болгосон төслийн байршлын ойролцоох бүс нутгийг ямар нэгэн шувуу ашигладаг эсэхийг баталгаажуулах боломжгүй гэсэн боловч Хар Ус нуурын хойд хэсгийг ашигладаг эргийн шувууд голчлон нам доор нисдэг учраас мөргөлдөх, ялангуяа газар дээрхи дамжуулах шугамтай мөргөлдөх эрсдэлтэй байж болзошгүй гэж мэдэгдсэн.

Дэлхийн байгаль хамгаалах сан (ДБХС)-тай хийсэн уулзалтанд тэдний зүгээс Хар Ус нуурын өмнөд хэсгийн уулны бүс нутагт бусад уулархаг бүс нутаг уруу нүүж болзошгүй түүрайтан амьтан (аргаль, янгир гэх мэт) ба ирвэс байгаа эсэхийг тодорхойлох биологийн төрөл зүйлийн судалгаа хийхийг зөвлөсөн. Хэрэв эдгээр амьтад байгаа бол төсөл нь эдгээр амьтдын нүүдлийн маршрутанд нөлөөлөхгүй байлгахын тулд ногоон корридор байгуулах шаардлагатай болж болно.

Нарны фотовольтийн станц ба холбогдох дамжуулах шугам нь янз бүрийн зэрлэг амьтдын нүүдлийн маршрутад нөлөөлж болзошгүй асуудал байна. Зээлдэгч нь чухал байгалийн амьдрах орчныг тодорхой хэмжээгээр өөрчлөхгүй байх ба/буюу чухал биш байгалийн амьдрах орчны хувьд нарны цахилгаан станц/дамжуулах шугам нь чухал биш байгалийн амьдрах орчинд нөлөөлж болохоор байгаа, болох магадлал багатай үйл явдал болсон тохиолдолд авах тохирох нөлөөллийг бууруулах арга хэмжээг бэлтгэсэн байхад хангах Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуучлалын яам (БОНХАЖЯ)-ны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газраас зөвшөөрөл авах ёстой.

Ойрхон байх дэд бүтэц

Байршил В нь Оросоос (Увс аймгийн Улаангом хотын хойд зүгээс) ирж байгаа 110 киловольт (кВ)-ийн дамжуулах шугам, Өлгий сум уруу 35 кВ-ийн дамжуулах шугам, Өмнөговь сум уруу 10 кВ-ийн дамжуулах шугам, Ховд/Баян-Өлгийн аймаг (өмнө зүг) рүү 110 КВ дамжуулах шугам бүхий Өмнөговь сумын төвийн дэд станцийн (110/35/10кВ) хажууд байрлаж байна. Энэ дэд станц Өмнөговь сумын төвөөс 2 км зайтай газар оршиж байна.

Байршил В-тэй хамгийн ойрхон зам 2 км-ийн зайтай, хамгийн ойрхон галт тэрэгний зам зүүн зүгт 900 км зайтай Эрдэнэт хотод байна.

Сумын төвд хаягдал ус цэвэршүүлэх байгууламж байхгүй байна. Голчлон хаягдал усыг (угаалга үйлдэх, угаах, хоол хийхээс үүссэн) айл гэрийн гадаах нүх эсвэл бохирын байгууламжтай холбогдоогүй гэрийн гадаах нүхэн жорлонд хаяж байна.

3.3 БАЙРШИЛ С (ХОВД АЙМГИЙН МЯНГАД СУМАНД БУЮУ БАЙРШИЛ А-гаас хойд зүгт 10 км-ийн зайтай байрлах)

Байршил С-гийн сүүлийн үеийн зургийг доор тавилаа.

Site C : 10km North from Mayangad substation (From North to South)



Газар ашиглалт (Одоогийн)

Санал болгосон байршил бол одоо байгаа Мянгад дэд станц (2 x 110/ 35/ 6кВ) байрлах байршил А-гаас хойд зүгт 10 км-т байна.

Мянгад сумын Засаг даргын Тамгын газрын зүгээс байршил С (аливаа холбогдох дамжуулах шугамыг оруулан) нь төрийн мэдлийн газар болохыг баталгаажуулсан. Нарны цахилгаан станцийн байгууламжинд зориулан бүх тухайн бүс нутгийг ашиглах боломжтой. 15-60 жилийн хугацаатай зөвшөөрлийг дараа нь олгож болно. Засаг даргын Тамгын газар ба олон улсын хамгааллын зөвлөхийн ажиглалтаар уг газрыг албан ёсоор ашиглаагүй болохыг баталгаажуулсан. Ховд аймгийн Засаг даргын орлогч уг газрыг хөдөө аж ахуйн (бэлчээрийн мал аж ахуй) зорилгоор албан бусаар ашиглаж байх боломж бий гэдгийг мэдэгдсэн. Гэвч тухайн бүс нутагт байгаа малчдын тооны талаар тодорхой тооны мэдээлэл гаргаж өгөөгүй. 2016 оны 11-р сард байршилд очиход байршилд болон түүний ойр орчимд ямар нэгэн үйл ажиллагаа ажиглагдаагүй. Уг газар ямар ч өвлийн байгууламжууд байхгүй байна.

Газар ашиглалт (Ирээдүйд)

Мянгад сумын зүгээс байршил С болон түүний ойр орчмын газрыг ашиглах ямар нэгэн ирээдүйн төлөвлөгөө байхгүй.

Нийгэм

Байршил С-тэй хамгийн ойрхон хүн ам төвлөрсөн газар бол хойд зүгт 10 км зайтай байрлах Мянгад сумын төв болно. Энэ төвлөрсөн газрын нийгэм-эдийн засгийн мэдээллийг Бүлэг 3.1-л өмнө нь дурдсан байгаа. Байршил С-д үйлчилгээ эсвэл байгууламж байхгүй.

Ой мод

Санал болгосон байршилд ой мод байхгүй. 22.5 км-ийн зайтай өмнө зүгт Хар Ус нуур байгалийн цогцолбор газар байх ба чухал шувууны бүс нутаг болно.

Хэрэв энэ байршил сонгогдвол Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуучлалын яам (БОНХАЖЯ), Ойн бодлого, зохицуулалтын газрын захирлаас зөвшөөрөл авах шаардлагатай.

Биет соёлын өв

Сумын байгаль орчин, газрын мэргэжилтнүүд байршил С-д ямар нэгэн мэдэгдэх биет соёлын өв байхгүй гэж мэдэгдсэн. Хамгийн ойрхон албан ёсоор хүлээн зөвшөөрөгдсөн биет соёлын өв бол төслийн байршилаас барагцаагаар 55 км-т байрлах Сангийн хэрэм болно. Сангийн хэрэм бол Ховд аймгийн хойд хэсэгт байх Манжийн үеийн хэрмийн үлдэгдэл юм. Хэрмийн 18-р зуунд байгуулсан бөгөөд сүүлд Манжийн амбангийн байрлах газар болсон. Хэрэм нь дөрвөлжин зохион байгуулалттай, ханыг шавраар хийжээ.

Усны нөөцийн хангамж ба удирдлага

Байршил С-гийн хажууд ямар нэгэн худаг ажиглагдаагүй боловч Мянгад сумын засаг дарга газар доорх усны нөөц хангалттай (элбэг) гэж мэдэгдсэн. Хэдий тийм боловч усны хүрэлцээний талаар тодорхой мэдээлэл өгөөгүй (Засаг даргын тамгийн газрын санал бодлыг баталгаажуулахад найдвартай мэдээлэлтэй болох Дэлхийн Банкны үндсэн шаардлагын үнэлгээний оролдлогын талаар Байршил А-д дурдсныг үзнэ үү).

Уг газар хавар ба намар ерөнхийдөө салхитай байдаг учраас эдгээр үеүүдэд хавтанг илүү их угаах шаардлагатай болно.

ОУСК-ийн байгууламж баригчийн зааварчилгааны дагуу станцад шаардлагатай усны нөөцийн хэрэгцээ жилд 410-аас 615 м3 байна (41 м3/жил/МВ).

Экологи

Үндсэн шаардлагад нийсэн байдлын үнэлгээний дагуу байршил (санал болгосон дамжуулах шугамын замыг оруулан) нь ямар нэгэн албар ёсоор хамгаалагдсан газар байгуулагдахгүй ба ой мод устгахад хүргэхгүй. Гэвч сонгогдсон байршил Рамсар газраас ойролцоогоор 12.5 км-ийн зайтай бөгөөд Ховд голтой огтлолцох Хар Ус нуурын чухал усны шувууны бүс байдаг. Орон нутгийн иргэд Ховд гол ба Хар Ус нуурын ойролцоо газраар шувууд их нисдэг, дэлхийд ховордсон цагаантолгойт ямаансүүлт (*Oxyura leucoserphala*) үрждэг чухал газар гэж дурдсан.

Хар Ус нуур байгалийн цогцолбор газар хамгаалалттай бүсийн удирдлагатай үүлзалт хийхэд тэд газар дээр 1 км дамжуулах шугам тавин шувуу мөргөөлдөх магадлалыг ихэсгэх байршил С-гийн оронд 0.5 км газар доорх шугам ашиглах байршил А-г илүү үзэж байгаагаа илэрхийлсэн.

Ойрхон байх дэд бүтэц

Байршлаас хамгийн ойрхон зам 0.5 км зайтай. Хамгийн ойрхон гал тэрэгний зам байршлаас баруун зүгт 896 км-т байх Эрдэнэт хот юм. Шинэ хогийн цэг байршил С-гээс 10 км зайтай. Өөр ойрхон дэд бүтэц байхгүй. Мянгад сумын төвд (байршлаас 10 км зайтай) сургууль, цэцэрлэг, засаг захиргааны байгууллагууд байрлана. Мянгад сумын төвд хаягдал ус цэвэрлэх байгууламж байхгүй.

4. ҮҮСЭЖ БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛЛИЙН ТАНИЛЦУУЛГА

4.1 Барилга угсралтын ажлын нөлөөлөл

Газар ашиглалт

Байршил С-д жил бүр хэдэн сар мал бэлчээхэд газрыг ашиглаж болох малчин айлуудыг (1-5 айл) эдийн засгийн шилжилт хүргэж болзошгүй байна. Өөр мал бэлчээж болох газар олон байн нөлөөлөл бага боловч хэрэв байршил С сонгогдвол эдгээр нөлөөллийг Нүүлгэн шилжүүлэлтийн товч төлөвлөгөө (НШТТ)-ийн дагуу шийдвэрлэх шаардлагатай.

Нийгмийн нөлөөлөл

Дээр тодорхойлсон газар ашиглалтын нөлөөллөөс гадна богино хугацааны ажлын байр бий болох, орон нутгийн ханган нийлүүлэлтийн боломжоос болж нийгэм-эдийн засгийн нөлөөлөл голдуу эерэг байна. Богино хугацааны (түр) сөрөг нөлөөлөл бол барилга угсралтын ажлаас болж дуу чимээ/тоос үүсэх (доор дурдсан байгаа) ба БОУТ-ын дагуу зохицуулах шилжин ирэх ажилчид (200-гаас доош тооны хүн) байна. Түр зуур (6-гаас доош тооны сар) ирэх орон нутгийн бус шилжин ирэх ажилчид орон нутгийн үйлчилгээ эсвэл дэд бүтцэд дарамт үзүүлэхгүй ч түр зуурын зарим нийгмийн дарамт үзүүлж магадгүй.

Агаарын чанар

Моторын утаанаас нүүрстөрөгчийн исэл, азотын исэл ялгарахаас гадна чанар муутай дизель түлшнээс тоос болон хүхрийн давхар исэл ялгарна.

Хүмүүсийн хөдөлгөөн, зүй бусаар хадгалсан барилгын материал эсвэл тээврийн хэрэгсэл ба тоног төхөөрөмжийн хөдөлгөөнөөс тоос дэгдэлт үүсэх нь бий

Дуу чимээ

Барилга угсралтын үйл ажиллагаа нь орон нутгийн орон суугчид ба зэрлэг амьтдын зан үйл, дадлыг алдагдуулж болохуйц дуу чимээ гаргах нь бий.

Гадаргын урсацын чиглэлийн өөрчлөлт

Газар цэвэрлэх ба газрын гадаргууны хэлбэрт өөрчлөлт хийх үйл ажиллагаа нь гадаргын урсацын чиглэлийг өөрчлөн, тухайн орчин бүст үерлэлт бий болгох боломжтой

Хөрс хуулалт

Газар бэлтгэх үйл ажиллагаанд хөрс хуулах/хадгалах үйл ажиллагаа орж болзошгүй

Ургамлын хаягдал гарах

Газар бэлтгэх үйл ажиллагаанд одоо байгаа ургамлыг цэвэрлэх/зайлуулах үйл ажиллагаа орж болзошгүй

Барилга угсралтын ажилтай холбоотой хатуу хог хаягдал

Аюулгүй: Баглаа боодол, барилга угсралтын идэвхгүй материалын хаягдал мөн магадгүй ажилчдын кампийн ахуйн хог хаягдлыг зохих байдлаар зайлуулах шаардлагатай t

Аюултай: Ашигласан тос, тослох материал, илүүдэл будаг эсвэл гадуур бүрхэх материал, цавуулаг бодистой тусгайлан харьцах шаардлагатай

Хаягдал ус

Цэвэрлэх тоног төхөөрөмжөөс гарах хаягдал ус ба магадгүй эрүүл ахуйн байгууламж болон ажилчдын кампаас гарах ахуйн хаягдал усыг зохих байдлаар зайлуулах шаардлагатай.

Соёлын өв

Малтлагын үйл ажиллагааны үеэр соёлын, шашны эсвэл түүхий ач холбогдол бүхий түүхийн эд өлгийн зүйлс санамсаргүй олоход нь бий

Ажилчдын аюулгүй байдал

Барилга угсралтын үйл ажиллагаа нь ажилчдыг аюулгүй байдал, эрүүл мэндэд нь нөлөөлж болзошгүй нөхцөл байдалд ажиллах, эд материалтай харьцахад хүргэнэ.

4.2 Үйл ажиллагааны нөлөөлөл

Нийгэм

Тус хөрөнгө оруулалтын хамрах хүрээнд цахилгаан хангамжийн үйлчилгээнд ямар нэгэн хэрэглэгчийг шинээр холбохгүй гэж тооцоолж байгаагаас гадна цаашдын хөрөнгө оруулалтын үр дүнд шинэ холболт бий болохгүй гэж тооцоолж байна. Одоогийн нөхцөлд Орос улсаас байнгын бөгөөд найдвартай цахилгаан хангамжийг авч ашигладаг мөн хэрэглэгчид (төв суурин газруудад) аль хэдийн үг үйлчилгээнд холбогдсон байгаа тул цахилгаан хэрэглэгчийн үнэнд өөрчлөлт орох болон найдвартай байдал нэмэгдэх боломж зэрэг тооцоологдоогүй болно. Барилга угсралтын ажлын явцад голчлон чадвар шаардсан ба зарим өдөр тутмын үйл ажиллагаанд чадвар шаардахгүй барагцаагаар 10-30 тооны урт хугацааны ажлын байрны боломж гарна. Орон нутгийн иргэд, ялангуяа эмэгтэйчүүдийг ажилд авах ба тэдгээрт сургалт явуулахыг эн тэргүүнд тавина. Ажилчид олсон орлогоо орон нутагт зарцуулах эсвэл орон нутгийн иргэд (хэрэв зохих чадвар, мэдлэгтэй бол) ажиллах үед орон нутгийн эдийн засагт хувь нэмэх болох боловч энэ нь барилга угсралтын явцад хийгдэх хувь нэмрээс бага байна.

Үзэгдэх орчны сарнилт

Нарны цахилгаан станцийн хавтангаас нарны гэрэл ойход жолоочдын хараанд нөлөөлөхөөс гадна нүүдлийн шувуудын нислэгийн чиглэлийг сарниулах магадлалтай.

Газар доор ус хэрэглэх боломж

Уламжлалт хавтан ашиглахад тодорхой хэмжээгээр газар доорх ус багасах ба улмаар газар доорх усны дээд түвшинг бууруулан, бусад хэрэглэгчдийн ус ашиглах боломжид нөлөөлөх нь бий.

Хавтанг угаасан хаягдал ус

Уламжлалт хавтан ашиглахад хавтан угаасан хаягдал усанд бохирдуулагч бодис байх магадлалтай ба хүлээн авах усны эх үүсвэрийг бохирдуулж болзошгүй.

Аюултай хаягдал

Арчилгааны үеэр хэлхээ салгуур, эргэх хувиргагч ба трансформатороос гоожсон тос нь хөрсийг бохирдуулах боломжтой

Экологи

Нарны фотовольтийн хавтангууд болон дамжуулалтын шугамын маршрутанд сонгогдсон байршлуудын аль аль нь нүүдлийн шувууны-зам болон газарт үүрээ засдаг шувуудын үүрээ засах хэлбэр, газар дээр зэрлэг амьтадын нүүдлийн чиглэл эсвэл мал аж ахуйн бэлчээрийн газарт хамаарч магадгүй юм.

5. ГОМДОЛ ШИЙДВЭРЛЭХ ТОГТОЛЦОО

БОНУХ-т тодорхойлсоны дагуу төслийн нарны хүчний бүрэлдэхүүн 2-т зориулан энэ хөрөнгө оруулалтыг авах сонгогдсон аливаа байршлын хувьд гомдол шийдвэрлэх тогтолцоог хэрэгжүүлэх болно. Баруун Бүсийн Эрчим Хүчний Систем (ББЭХС) нь нь өртөмхий газрууд (эмнэлэг, сургууль, номын сан зэрэг)-ын ойролцоо эсвэл онцгой цаг хугацаа (баяр наадам, амралт, шашны ёслолын өдрүүд гэх мэт)-ны үеэр барилга угсралтын үйл ажиллагааны тогтоосон хуваарийг орон нутгийн эрх бүхий хүмүүс (орон нутгийн доод нэгж, тосгоны удирдлагууд)-тэй харилцан тохиролцоно. ББЭХС нь орон нутгийн иргэдэд барилга угсралт ба ажлын хуваарь, үйлчилгээний тасалдал, замын хөдөлгөөний өөрчилсөн чиглэл, түр хугацааны автобусны чиглэл, тэслэх ба нураах үйл ажиллагааны талаар зохих байдлаар мэдээлнэ.

Аливаа өртсөн иргэдэд санал хүсэлт, гомдлын талаарх дуу хоолойгоо хүргэх боломжоор хангахын тулд барилга угсралтын ажлын бүх талбар дээр төслийн талаарх мэдээллээс гадна талбар хариуцсан менежер, байгаль орчны ажилтан, эрүүл мэнд болон аюулгүй ажиллагаа хариуцсан албан хаагчидтай холбогдох мэдээлэл, утасны дугаар, бусад холбоо барих мэдээллийг агуулсан Мэдээллийн самбарыг байрлуулна. Барилга угсралтын ажлын гүйцэтгэгч нь орон нутгийн иргэдийн ойролцоо буюу дунд төвөг чирэгдэл, үймээн самуун үүсгэхгүй байвал зохино.

Шалтгаанаас үл хамааран, өргөдөл гомдлын тогтолцоо нь өртсөн иргэдийн бүх хэсэг ямар нэгэн зардал, хариу цээрлүүлэлтээс ангид, шуурхай хандах боломжтой, хариуцлагатай бөгөөд соёлын хувьд тохиромжтой ил тод процессийг ашиглан өртсөн иргэдийн гомдол, саналыг шуурхай шийдвэрлэнэ.

Гомдлын шийдвэрлэх процесс нь тухайн гомдлын цар хүрээнд тохируулан арга хэмжээг санал болгоно. Уг процесс нь дараах байдлаар явагдана:

- Хэвийн ажлын үйл ажиллагааны үеэр гүйцэтгэгчид буюу ББЭХС-ийн албан хаагчдын шийдвэрлэх боломжтой санал, гомдлыг нэн даруй шийдвэрлэнэ. Тус гомдлын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл (юу, хэзээ, огноо, өдрийн цаг, хүйс, бусад ажиглалтууд), гомдол мэдүүлэгчийн холбоо барих мэдээлэл, арга хэмжээ/хэмжээнүүд болон хаасан огноо зэргийг тэмдэглэнэ. Гомдлыг утсаар, шуудан, цахим шуудангаар ББЭХС рүү эсвэл ББЭХС рүү гомдлыг уламжлах сумын төлөөлөгчид биеэр гаргах боломжтой.
- Нэн даруй буюу гүйцэтгэгч, ББЭХС-ийн албан хаагчдын шийдвэрлэх боломжгүй төсөлтэй холбоотой бусад гомдлыг боломжтой бол ажлын арван таван өдөрт багтаан богино хугацаанд зуучлуулахаар ТУН-ийн хамгааллын мэргэжилтэнд эхлээд мэдэгдэнэ. ТУН-ийн хамгааллын мэргэжилтэн нь өртсөн хүн (хүмүүс) буюу өртсөн бүлгийн оршин суугаа газартай ойр газар нээлттэй зөвөлгөөнд гомдолтой холбогдох этгээдүүд болон гомдол мэдүүлэгчийг оролцуулан зуучлах сонголыг зохион байгуулна. Гомдол мэдүүлэгч нь тус явцад дэмжигчидын хамт оролцохыг дэмжинэ.
- Хэрэв зуучлалын үйл ажиллагаа амжилтгүй болвол эсхүл уг асуудал нь үндэслэлтэй бол өртсөн этгээд нь аль ч хугацаанд Монгол Улсын хууль тогтоомж, журамд нийцүүлэн Монголын шүүх тогтолцоогоор дамжуулан бичгэн буюу аман гомдол гаргаж болно.

Ямар ч үед төслийн гомдол шийдвэрлэх тогтолцоо тухайн санал, гомдлыг шийдвэрлэхэд хангалтгүй гэж үзвэл Дэлхийн Банкны гомдол шийдвэрлэх үйлчилгээ болон Дэлхийн Банкны Хяналт шалгалтын комисст хандах боломжтой юм. Дэлхийн Банкны Гомдол шийдвэрлэх үйлчилгээ (ГШҮ)-нд гомдол хэрхэн мэдүүлэх тухай мэдээллийг <http://www.worldbank.org/GRS> хаягаар үзэж болно. Дэлхийн

Банкны Хяналт шалтгалтын комисст гомдол хэрхэн мэдүүлэх тухай мэдээллийг www.inspectionpanel.org хаягаар үзэж болно.

Хүлээн авсан бүх гомдлыг ТУН-ийн Хамгааллын мэргэжилтнээр тэмдэглүүлэн, хүргүүлэх ба ТУН дээр гомдол мэдүүлэгчийн талаарх мэдээлэл, огноо, гомдлын шалтгаан, асуудлыг шийдвэрлэхээр авсан алхмууд, үр дүн ба огноо, цаашид авах алхмууд, эцсийн шийдвэрлэх хугацаа болон эцсийн шийдвэрлэх хугацаа хүртэл эхний мэдэгдлээс хойш өнгөрсөн хугацааг тэмдэглэсэн матрикт гомдлуудыг нэгтгэнэ. Уг матриксийг Дэлхийн Банкны ажлын хэсэг тогтмол хянах боломжтой байхаар шинэчлэн, тогтмол тайланд нэг хэсэг болгон оруулна. Гомдлын шалтгаануудын талаарх дүн шинжилгээг цаашдын дэд төслийн төлөвлөлтийг зохих байдлаар сайжруулах үндэслэл болгох зорилгоор гүйцэтгэнэ.

